

Санхүү, хөрөнгө оруулалтын газар

Газар, хэлтсийн нэр	Үндсэн чиг үүрэг
3. Санхүү, хөрөнгө оруулалтын газар	<ul style="list-style-type: none"> • Төсвийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах; • хөтөлбөр, үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтөд мэргэжлийн арга зүй, зохион байгуулалтаар хангах; • Барилга, хот байгуулалтын сайдын багцад батлагдсан улсын төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалт болон урсгал төсвийн санхүүжилтэд хяналт тавих; • Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, салбарын бодлого, стратеги, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санхүү, хөрөнгө оруулалтын нэгдсэн удирдлагаар хангах; • салбарын хөрөнгө оруулалтын урт, дунд хугацааны стратеги төлөвлөлт, хөтөлбөр төслийн эдийн засгийн үр өгөөж, үр дүнгийн шинжилгээ хийх, холбогдох байгууллага, нэгжүүдтэй хамтран ажиллах; • салбар хоорондын болон аймаг, нийслэл, орон нутгийн уялдааг сайжруулах, хөрөнгө оруулалтын оновчтой, үр дүнтэй байдлыг хангахад хамтын ажиллагааг өргөжүүлэх, хамтран ажиллах; • хөрөнгө оруулалтын уялдааг сайжруулах, үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн төсөв, хөрөнгө оруулалтын нэгдсэн төлөвлөлтийг хийж, батлуулах; • улсын төсөв, гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, гэрээний хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих; • улсын төсөв, гадаадын зээл тусламжаар хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр дүнг дээшлүүлж, гүйцэтгэлийг хянах, удирдлага, зохицуулалтаар хангах; • хөрөнгө оруулалтын үр дүнгээр бий болсон бүтээн байгуулалт, хөрөнгийг өмчлөлд шилжүүлэх, ашиглалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэн ажиллах; • салбарын хөрөнгө оруулалтын судалгаа, мэдээллийг бүрдүүлж, түүнийг шинэчлэх, баяжуулах, хүртээмжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж, яамны удирдлага, нэгж, холбогдох байгууллагыг мэдээ, мэдээллээр хангаж ажиллах.
3.1. Санхүү, төрийн сангийн хэлтэс	<ul style="list-style-type: none"> • Төсвийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилтийг хангах; • хөтөлбөр, үр дүнд суурласан төсвийн төлөвлөлтөд мэргэжлийн зохион байгуулалт, арга зүйн дэмжлэг үзүүлэх; • барилга, хот байгуулалтын сайдын багцад батлагдсан улсын төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалт болон урсгал төсвийн зардлыг хуваарилах, санхүүжүүлэх, тайлагнах; • яамны төв аппаратын төсвийн урсгал зардлын эх үүсвэрийг батлагдсан төсвийн дагуу үр ашигтай зарцуулах, тайлагнах; • яамны эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр хийж, төрийн өмчийн ашиглалт, хадгалалтад, хамгаалалтад хяналт тавих, тайлагнах; • төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайланг хагас, бүтэн жилээр нэгтгэн гаргаж, Үндэсний аудитын газраар

	<p>аудит хийлгэн баталгаажуулж, тайлагнах ажлыг зохион байгуулах;</p> <ul style="list-style-type: none">• салбарын төрийн сангийн өдөр тутмын гүйлгээг хянан баталгаажуулах, холбогдох мэдээ тайланг гаргах;• шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангахад санхүүгийн мэдээ, мэдээллээр дэмжлэг үзүүлэх.
--	---